

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.080.01

<p>Байгаль орчин. Хөрсний чанар. Тайлбар толь. 1-р хэсэг: Хөрс хамгаалах бохирдлоос сэргийлэхтэй холбогдох нэр томьёо тодорхойлолт</p> <p>Environment. Soil quality. Vocabulary. Part 1: Terms and definitions relating to the protection and pollution of the soil</p>	<p>MNS ISO 11074-1 : 2001</p>
---	--------------------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2001 оны 04-р сарын 26-ний өдрийн 21 дугаар тогтоолоор батлав.

2001 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

ISO 11074-1 Олон улсын энэхүү стандарт нь хөрсний чанарыг тодорхойлоход хэрэглэдэг нэр томьёоны жагсаалтыг тодруулахад чиглэгдсэн. Энэ нь хөрс хамгаалах, хөрсний бохирдлоос сэргийлэх зэрэг үндсэн тулгуур ойлголтод хамаатай.

ТАЙЛБАР 1: ОУСБ-ын албан ёсны хэл болох англи, франц, орос хэл дээр гарсан тайлбард нэмэлт болгон ISO 6107-г герман хэл дээр мөн гаргасан; энэ тайлбар толийг ОУСБ-ын 147-р техникийн хорооны хүсэлтээр, хариуцлагыг нь Герман, Австри, Швейцарь улс хүлээнэ гэсэн нөхцөлтэйгээр хэвлэн гаргасан. Гэхдээ зөвхөн ОУСТ-ын албан ёсны хэл дээр гарсан тайлбарийг л ОУСБ-ын албан ёсны тайлбар гэж үзэх ёстой.

2. Норматив ишлэл

Дараах стандартууд нь энд өгөгдсөн стандартад иш татсан утгаараа ISO 11074-ийн тухайн хэсгийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж, түүний гол үндэс нь болж өгнө. Хэвлүүлж тараах үед стандарт нь хүчинтэй байсан. Бүх стандарт шинэчлэгддэг болохоор энэхүү олон улсын стандартын талаар зөвшилцөөнд хүрсэн талууд дор дурдсан стандартуудын хамгийн шинэ хувилбарыг хэвлэн гаргах боломжийг эрж хайх шаардлагатай. ОУЦТК, ОУСБ-ын гишүүн орнууд одоо хүчинтэй байгаа олон улсын стандартуудыг бүртгэж авсан байх шаардлагатай.

ISO 6107-6: 1986 он, Усны чанар- Тайлбар толь, 6 дугаар хэсэг

1. Хөрс, бодисуудын чанартай холбогдох нэр томьёо

1.1 **ялгах итгэлцүүр:** хоёр өөр төрлийн орчинд оршиж буй тухайн бодисын концентрацийн харьцаа

- 1.1.1 **хөрс-усны оролцооны харьцаа** Кд: хатуу хөрс ба устай хөрсөн дахь тухайн бодисын концентрацийн харьцаа
- 1.1.2 **хөрсөн дахь органик бодис ба ус оролцооны итгэлцүүр**: хөрсөн дахь органик бодис ба устай хөрсөн дэх тухайн бодисын концентрацийн харьцаа
ТАЙЛБАР: Энэхүү итгэлцүүрийг хөрсөн дахь органик устөрөгчийн концентрацид харьцуулсан байдлаар илэрхийлдэг.
- 1.1.3 **биоконцентрацийн хүчин зүйл**: организм ба хөрсөнд агуулагдаж буй бодисын концентрацийн харьцаа
- 1.1.4 **хөрс ургамлын оролцооны итгэлцүүр**: хөрс ба ургамалд агуулагдаж буй бодисын концентрацийн харьцаа
- 1.2 **шүүх чадамж**: хатуу, ууссан, хийн байдалд байгаа бодисыг өөртөө шингээн авч үлдэх хөрсний чадамж
- 1.3 **шингээх**: хөрсний гол бүрдүүлэгч хэсгүүдийн бодисуудыг өөртөө татах, харилцан холбож өгөх чадамж
ТАЙЛБАР: Сорбцлох механизмын жишээ: ион солилцоо, гадаргуугийн шингээлт, хөрсний органик бодист химийн органик бодисууд уусах гэх мэт.
- 1.4 **Химийн бодисын үйлчлэлийг тэсвэрлэх чадамж**: бодисуудын химийн өөрчлөлтийг тэсвэрлэх чадамж
ТАЙЛБАР:
1. Энэ чанар нь хүрээлэн байгаа орчны нөхцөл байдалтай ямагт холбогдох байдаг. Тиймээс аль нэг төрлийн хөрсөнд тэсвэртэй байдаг бодис өөр төрлийн хөрсөнд яг түүн шигээ байж чаддаггүй.
2. Бодисын тэсвэрлэх чадамжийг хүрээлэн байгаа орчны нөхцөл байдал тов тодорхой байх тохиолдолд энэхүү үйлчлэлд орох хугацааны тэн хагастай тэнцэнэ гэж ойлгож болно.
- 1.5 **задрал**: нарийн бүтэцтэй органик бодис физик, хими, боиологийн процессын үр дүнд илүү энгийн молекул, ион болон задрах
- 1.5.1 **биологийн задрал**: амьд организмуудын үйлчлэлээр задралд орох
- 1.5.2 **биологийн биш задрал**: фотолиз, гидролиз, исэлдэлт зэрэг физик, химийн процессын үйлчлэлээр задралд орох
- 1.5.3 **эрдэсжих**: органик бодисууд болон органик нэгдлүүд нүүрс хүчлийн давхар исэл, ус, гидрид, оксид болон бусад төрлийн эрдсийн давс болон задрах
- 1.5.4 **гумус болж задрах**: организм ба тэдгээрийн зарим хэсэг задралд орох, тэр нь цаашаа гумусын бодис болон задрах

1.5.5 **анхан шатны задрал:** бодис нь задралд орсон буюу түүний молекулын бүтцэд нь өөрийн онцлог байдлаа хадгалан үлдэж чадахааргүй хэмжээний өөрчлөлтөд орох
ТАЙЛБАР: ISO 6107-6:1986-ын дагуу.

1.5.6 **биологийн задралын хязгаар:** тухайн бодисыг бүрэн эрдэсжүүлэхэд хүргэх биологийн задрал

1.6 **хөрсний аюултай нөхцөл байдал:** хөрсний нөхцөл байдал барилгын ба суурийн материалд гэмтэл учруулах хэмжээнд хүрэх

2. Хөрсөнд явагддаг процесстой холбогдох нэр томьёо

2.1 **хязгаарлах хүчин зүйлс:** хөрсний үйлчлэл, хөрс ашиглалтыг хязгаарлахуйц аливаа нөхцөл байдал үүсч бий болох

2.2 **хөдөлгөөнд оруулах:** хөрс болон түүн дэх бодисуудыг хөдөлгөөнт байдалд оруулах

2.3 **хөдөлгөөнийг зогсоох, сааруулах:** хөрс болон түүн дэх бодисуудын хөдөлгөөнийг түр хугацаагаар ба бүр зогсоох

2.4 **шилжин байрлах:** ууссан ба уусаагүй бодисыг ус, агаар, хүний үйл ажиллагаа болон хөрсөн дахь организмуудын үйлчиллээр хөрсний давхаргад, хөрсний гадаргууд шилжүүлэх

2.5 **аккумуляц:** хөрсөнд орж ирж байгаа бодисын хэмжээ нь тэндээс гарч буй бодисынхоос их байх тохиолдолд хөрсөн дахь тухайн бодисын концентраци нэмэгдэх

2.6 **гаднаас орж ирэх бодис:** хүрээлэн буй орчны өөр төрлөөс хөрсөнд орж ирэх бодисын хөдөлгөөн

2.7 **хөрсөнд орж ирэх бодисын цэгэн эх үүсвэр:** хөрсөнд бодис тодорхой хязгаартай байнгын цэгэн эх үүсвэрээс орж ирэх

ТАЙЛБАР:

1. цэгэн эх үүсвэр гэдэгт яндангийн утаа тортог, ослын улмаас нефть-химийн бүтээгдэхүүн асгарах, хогийн цэгүүд, үйлдвэрийн хаягдал тархах, ариутгах татуургын сүлжээ эвдэрч, яндан задрах зэрэг тохиолдлууд орно

2. цэгэн эх үүсвэрээс хөрсөнд бодис орсноор хязгаарлагдмал хүрээнд, эсвэл тухайн газар нутгийн хөрс тодорхой төрлийн бодисоор нилдээ бохирдож болно. /4.6 ба 4.7-г үз/

2.8 **хөрсөнд орж ирэх бодисын цэгэн бус, тархай эх үүсвэр:** хөдөлгөөнт, томоохон газар нутаг болон олон эх үүсвэрээс хөрсөнд бодис орж ирэх

ТАЙЛБАР:

MNS ISO 11074-1 : 2001

1. хөдөлгөөнт эх үүсвэрийн тоонд автомашин, хөдөө аж ахуйн үйлдвэрээс гарах бодис, хот, бүс нутгийн хог хаягдал, үерээр урсан орж ирэх хог зэргийг оруулдаг.
2. тархай эх үүсвэрээс тухайн газар нутгийн хөрсөнд голцуу нэгэн төрлийн бодис орж ирдэг. Эх үүсвэрт ойр байгаа газарт, бороо, үер дайран өнгөрдөг газрын хөрсөнд тухайн төрлийн бодис их хэмжээгээр орж ирэх нь бий.

2.9 **хөрснөөс бодис гадагшлах:** хөрснөөс бодис гадагшилж, хүрээлэн буй орчны өөр төрөлд шилжих хөдөлгөөн

2.10 **угаагдах:** хөрсөн дахь хатуу бодис ус зэрэг шингэн бодисын хөдөлгөөнөөр угаагдан гарах

2.11 **шавар зөөгдөн гарах:** хөрсний давхрага дахь шаварлаг хэсгүүд шилжих хөдөлгөөн

3. Хөрсний чанартай холбогдох нэр томъёо

3.1 **хөрсний чанар:** хөрсний үйлчлэл, хөрс ашиглахтай холбогдох эерэг, сөрөг бүх талыг нь агуулсан цогц шинж чанар

3.2 **хөрсний үржил шим:** хөрсний чанарыг ургамлын өсөлт хөгжилтийг хангах гэсэн утгаар нь авч үзэх

3.3 **хөрсний бүтээмжит чанар:** байгаа нөхцөл байдалд өндөр ургац авах нөхцлийг бүрдүүлж чадах хөрсний байгалийн шинж чанар

3.4 **хөрсний чадамж-бүтээмжит чанар:** тохиромжтой нөхцөл байдлыг хангасан нөхцөлд /бордоо, пестицид хэрэглэх, усжуулалт, хөрс боловсруулалт гэх мэт/ өндөр ургац авах нөхцлийг бүрдүүлж чадах хөрсний өөрийнх нь шинж чанар

3.5 **хүний үйл ажиллагааны нөлөө:** хүний үйл ажиллагааны улмаас хөрсний шинж чанар өөрчлөгдөх

3.6 **хөрс гэмтэх:** хөрсний зарим шинж чанар муудсанаар түүний аль нэгэн, бүх үүрэг функцэд, эсвэл хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх

3.7 **эмзэг хөрстэй газар:** гадаад орчны нөхцөл байдал бага зэрэг өөрчлөгдөхөд хөрсний үүрэг функцэд нэлээд хэмжээний өөрчлөлт ордог эмзэг газрын хөрс

3.8 **байгалийн концентраци:** судлагдаж буй хөрсөн дахь бодисуудын геологи, хөрс үүсэх нөхцлийн дундаж концентраци

3.9 **хөрсөнд орж ирэх бодисын зөвшөөрөгдөх хэмжээ:** нэг болон хэд хэдэн бохирдуулагч бодисын тоо хэмжээ үүнээс бага байхад тухайн бодис нь хүрээлэн байгаа орчинд нэг их хортой нөлөө үзүүлэхгүй гэж орчин үеийн шинжлэх ухаан үздэг зөвшөөрөгдөх хэмжээ буюу босго

3.10 **концентрацийн хязгаар**: нэг болон түүнээс дээш бохирдуулагч бодисын концентраци үүнээс бага байхад хөрс болон хүрээлэн буй орчны мэдрэмтгий элементүүдэд мэдэгдэхүйц хортой нөлөө үзүүлэхгүй гэж орчин үеийн шинжлэх ухаанд үздэг хязгаар

3.11 хөрсөнд аюултай нөлөө үзүүлдэг бодисууд: шинж чанар, тоо хэмжээ ба концентраци зэрэг нь хөрсний үйлчлэлд болон хөрс ашиглалтанд таагүй нөлөө үзүүлэх бодисууд.

3.12 хөрс давсжих: хөрсөнд давс хуримтлагдах, мөн усанд уусдаг давснууд тэнд хуримтлагдах

3.13 үржил шим нь ургамалд шилжих чадамж: хөрсөн дахь үржил шимт бодисууд ургамалд шилжих чадамж

4. Хөрс хамгаалахтай холбогдох нэр томьёо

4.1. **хөрс хамгаалах**: хөрс болон хөрсний үүрэг функцийг хэвээр нь хадгалах, нөхөн сэргээхэд чиглэсэн удаан хугацааны арга хэмжээ

4.2. **санал болгож буй үнэт чанар**: эрх бүхий байгууллагаас хуулийн ямар нэгэн үүрэг ногдуулалгүйгээр санал болгож буй хөрсний үнэт чанар

4.3. **хуулиар тогтоосон үнэт чанар**: хууль эрхийн актаар тогтоосон үнэт чанар

4.4. **сэжиг бүхий газар**: хүрээлэн буй орчин, ялангуяа хүний эрүүл мэндэд хортой гэж сэжиг төрүүлж буй газар

4.5. **аюултай газар**: хүрээлэн буй орчин, ялангуяа хүний эрүүл мэндэд хортой гэдэг нь тогтоогдсон газар

4.6. **тодорхой хүрээнд бохирдсон газар**: зарим хэсэгт нь хөрсөнд аюултай нөлөө үзүүлдэг бодисын концентраци өндөртэй газар

ТАЙЛБАР: бохирдол хязгаарлагдмал хүрээнд тархсан байхаас гадна тухайн газрын хүрээнд бохирдуулагч бодисын концентраци ч мөн ихээхэн ялгаатай байдаг.

4.7. **нэгэн төрлийн бодисоор бохирдсон газар**: хөрсөнд аюултай нөлөө үзүүлдэг нэгэн төрлийн бодисоор бохирдсон газар

ТАЙЛБАР: бохирдол нэлээд өргөн хэмжээгээр тархсан, энэ газрын хүрээнд бохирдуулагч бодисын концентрацийн ялгаа нэг их биш

4.8. **эрсдэлийн үнэлгээ**: бохирдсон газар нь хүн ба хүрээлэн буй орчинд ямархуу сөрөг нөлөө үзүүлэхийг бохирдлын гарал, мөн чанар, тархалт болон бохирдол гарах магадлал зэргийг харгалзан үнэлж, цэгнэх

MNS ISO 11074-1 : 2001

4.9. **хөрсийг нөхөн сэргээх:** хөрсний үүрэг, функц, цаашдын ашиглалтыг сайжруулах, хүн ба байгаль орчныг аюулаас сэргийлэхэд чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

4.10. **бохирдлыг бууруулах:** хөрсний үйлчлэл, цаашдын ашиглалтыг сайжруулах зорилгоор хөрсөн дэх бохирдуулагч бодисыг бүрэн болон хэсэгчлэн зайлуулах

5. Нэмэлт нэр томьёо

5.1. **индикатор бодис:** хэсэг бүлэг болон холимог бодисыг төлөөлж чадах бодис-индикатор

5.2. хөрсний дээжийн сан:

- дээж авах үед тухайн материал чухам ямар байдалд байсныг баримтжуулах
- аналитик аргуудад хяналт тавих гэсэн үндсэн хоёр зорилгоор хөрсний дээж, индикатор бодисыг системтэйгээр ба түр хугацаанд авч цуглуулах, удаан хугацаанд хадгалах ажиллагаа

5.3. **хөрсөнд байнгын хяналт тавих талбай:** тодорхой шалгуурын дагуу сонгож авсан, хэсэг газрын хөрсийг төлөөлж чадахуйц хяналтын тусгай талбайд удаан хугацааны ажиглалт хийсний үр дүнд бохирдуулагч бодис нь байгаль орчинд ямархуу нөлөө үзүүлдэг талаар мэдээлэл цуглуулах

5.4. **хөрс:** органик бодисын эрдэс хэсэг, ус, агаар болон амьд организмууд зэргээс бүрдсэн дэлхийн гадаргын дээд давхрага

Үсгийн дарааллын гарчиг

A

биологийн биш задрал 1.5.2.
биологийн биш задрал 1.5.2.
аккумуляц 2.5.
хөрсний аюултай нөхцөл байдал 1.6.
хүний үйл ажиллагааны нөлөө 3.5.

B

байгалийн концентраци 3.8
биоконцентрацийн хүчин зүйл 1.1.3
биологийн задрал 1.5.1
биологийн задрал 1.5.1

C

концентрацийн хязгаар 3.10
хөрсөнд орж ирэх бодисын зөвшөөрөгдөх хэмжээ 3.9

D

хөрс гэмтэх 3.6
задрал 1.5
бохирдлыг бууруулах 4.10
хөрсөнд орж ирэх бодисын цэгэн бус, тархай эх үүсвэр 2.8

F

шүүх чадамж 1.2

G

санал болгож буй үнэт чанар 4.2

H

гумус болж задрах 1.5.4

I

хөдөлгөөнийг зогсоох, сааруулах 2.3

L

Угаагдах 2.10
хуулиар тогтоосон үнэт чанар 4.3
хязгаарлах хүчин зүйлс 2.1
тодорхой хүрээнд бохирдсон газар 4.6

M

Эрдэсжих 1.5.3
хөдөлгөөнд оруулах 2.2
хөрсөнд орж ирэх бодисын цэгэн бус, тархай эх үүсвэр 2.8

N

хөрсөнд орж ирэх бодисын цэгэн бус, тархай эх үүсвэр 2.8

P

ялгах итгэлцүүр 1.1
хөрсөнд байнгын хяналт тавих талбай 5.3
Химийн бодисын үйлчлэлийг тэсвэрлэх чадамж 1.4
үржил шим нь ургамалд шилжих чадвар 3.13
хөрсөнд орж ирэх бодисын цэгэн эх үүсвэр 2.7
хөрсний чадамж-бүтээмжит чанар 3.4
анхан шатны задрал 1.5.5
аюултай газар 4.5

MNS ISO 11074-1 : 2001

R

эрсдлийн үнэлгээ 4.8

S

эмзэг хөрстэй газар 3.7

хөрс 5.4

хөрс гэмтэх 3.6

хөрсний үржил шим 3.2

хөрсөн дахь органик бодис ба ус оролцооны итгэлцүүр 1.1.2

хөрс ургамлын оролцооны итгэлцүүр 1.1.4

хөрсний бүтээмжит чанар 3.3

хөрс хамгаалах 4.1

хөрсний чанар 3.1

хөрсийг нөхөн сэргээх 4.9

хөрс давсжих 3.12

хөрсний дээжийн сан 5.2

хөрс-усны оролцооны харьцаа Кд 1.1.1

шингээх 1.3

гаднаас орж ирэх бодис 2.6

хөрснөөс бодис гадагшлах 2.9

хөрсөнд аюултай нөлөө үзүүлдэг бодисууд 3.11

сэжиг бүхий газар 4.4

T

шилжин байрлах 2.4

U

биологийн задралын хязгаар 1.5.6

нэгэн төрлийн бодисоор бохирдсон газар 4.7

ТӨГСӨВ.